



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/379.

Мандалговь

“Дундговио ногооруулъя дэд хөтөлбөр”-ийн
зардал батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “а”, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.2 дахь заалт, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 4, 7 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтын 4.7-д батлагдсан “Дундговио ногооруулъя дэд хөтөлбөр”-ийн зардлаас 80,000,000 (наян сая) төгрөгийн санхүүжилтийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Намрын мод тарих ажлыг хуулийн дагуу, богино хугацаанд батлагдсан зардалд багтаан шууд гэрээ байгуулан зохион байгуулахыг сумдын Тамгын газрын дарга нарт даалгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө, оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210511